

АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗРЫН 2015 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Авлигатай тэмцэх газар 2015 онд дэвшүүлсэн зорилт, жил, улирлын төлөвлөгөөнд тусгасан ажлуудыг бүрэн хэрэгжүүлсэн бөгөөд тайлант онд хийсэн ажил, хүрсэн үр дүнгийн талаар тайлагнаж байна.

Нэг. Авлигын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр


Шилэн дансны тухай хууль батлагдан 2015 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс мөрдөх болсонтой холбогдуулан "Төрийн байгууллагуудын авлигын эсрэг үйл ажиллагааг үнэлэх аргачлал"-ыг шинэчлэн боловсруулж батлуулан, байгууллагын цахим хаяг болон дээрх байгууллагуудын эрх бүхий албан тушаалтнаар нь дамжуулан хүргэж арга зүйн туслалцаа үзүүлж хамтран ажилласан.

2015 оны авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөгөө батлуулан хэрэгжүүлсэн Улсын Их Хурлаас байгуулагддаг 7 байгууллага /Монголбанк, Сонгуулийн ерөнхий хороо, Санхүүгийн зохицуулах хороо, Үндэсний аудитын газар, Үндэсний статистикийн хороо, Төрийн албаны зөвлөл, Хүний эрхийн үндэсний комисс/, 15 яам, Засгийн газрын тохируулагч, хэрэгжүүлэгч 28 агентлаг /Зэвсэгт хүчний жанжин штаб, Тагнуулын ерөнхий газар үнэлгээнд хамрагдаагүй/, аймаг, нийслэл 22, нийслэлийн 9 дүүрэг, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой 39 хуулийн этгээд, Хууль зүйн сайдын эрхлэх асуудлын хүрээний 2 байгууллага /Шүүхийн шинжилгээний хүрээлэн, Хууль сахиулахын их сургууль/ нийт 122 байгууллага хамрагдан уг аргачлалаар үнэлэгдлээ.

Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны үнэлгээгээр хангалтгүй үнэлгээ авсан Монголбанк, Үндэсний статистикийн хороо, Гадаад хэргийн яам, Эрүүл мэнд, спортын яам, Мал эмнэлэг үржлийн газар зэрэг байгууллагын удирдлагуудад цаашид үнэлгээгээ ахиулах, санаачилгатай ажиллах талаар зөвлөлдөх уулзалтыг зохион байгуулж ажилласаны үр дүнд Монголбанк 13.2, Үндэсний статистикийн хороо 31.5, Эрүүл мэнд спортын яам 30.4, Гадаад харилцааны яам 12.1, Мал эмнэлэг, үржлийн газар 9.4 хувь тус тус ахисан дүнтэй байна.

Нийт үнэлгээгээр жилийн улсын дундаж үнэлгээ 68,2 хувьтай байгаа нь өнгөрсөн онтой харьцуулахад 8.2 хувь, 2013 оны дүнтэй харьцуулахад 20 хувиар тус тус нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

Үнэлгээний үр дүнг өмнөх онуудтай харьцуулсан байдлаар үзүүлбэл:



2015 оны Авлигатай тэмцэх газрын үйл ажиллагааны төлөвлөгөөнд үндэслэн, мөн Хөндлөнгийн шинжээчдийн багаас өгсөн “Төрийн байгууллагуудын авлигын эсрэг үйл ажиллагааны 2014 оны үнэлгээ”-гээр жил дараалан бага оноотой үнэлэгдсэн, оноо нь буурсан, иргэдийн санал гомдол, судалгааны дүнд үндэслэн дараах байгууллагуудад авлигын эсрэг хууль тогтоомжийн хэрэгжилтийн байдалтай газар дээр нь танилцав. Үүнд:

- Ховд, Говь-Алтай, Увс, Дорноговь, Булган аймгийн нийт 52 сум
- Сангийн яам
- Хүүхдийн төлөө үндэсний газар, Оюуны өмчийн газар, Архивын ерөнхий газар, Мэдээлэл технологи, шуудан, харилцаа холбооны газар, Мал эмнэлэг, үржлийн газар, Хил хамгаалах ерөнхий газар, Иргэний харьяалал, шилжилт хөдөлгөөний ерөнхий газар зэрэг 7 агентлаг,
- Эрчим хүчний зохицуулах хороо, Харилцаа холбооны зохицуулах хороо–2
- Халдварт өвчин судлалын үндэсний төв, Гэмтэл согог судлалын үндэсний төв, Улсын нэгдүгээр эмнэлэг, Улсын гуравдугаар эмнэлэг, Өргөө амаржих газар, Хүрээ амаржих газар, Нийслэлийн Амгалан амаржих газар-7
- Налайх дүүрэг, Сүхбаатар дүүрэг, Багахангай дүүрэг, Багануур дүүрэг-4 дүүрэг
- Барилга хөгжлийн төв, Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ судалгаа мэдээллийн төв-2 төрийн өмчит байгууллага.

Дээрх яам, агентлагуудад ажиллахад өөртөө урамшуулал олгох шийдвэр гаргадаг, хууль тогтоомжид заасан мэдээллийн ил тод байдал хангалтгүй зэрэг нийтлэг зөрчил дутагдал байна.

Авлигатай тэмцэх газрын даргын 2012 оны 196 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар “Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө,

орлогын мэдүүлгийг бүртгэх, хадгалах эрх бүхий албан тушаалтны үйл ажиллагааны журам"-ыг баталсан бөгөөд уг журамд авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх чиг үүрэг тусгагдаагүй тул уг тушаалд нэмэлт өөрчлөлт оруулах зайлшгүй шаардлагын талаар дагуу өөрчлөлтийг боловсруулан Газрын даргын 2015 оны 9 дүгээр сарын 28-ны өдрийн А/98 дугаар тушаалаар батлуулан ажиллаж байна.

Ингэснээр авлига, ашиг сонирхлын зөрчлийн эсрэг хууль тогтоомжийн холбогдох зүйлд заасан нийтлэг үүргийн хэрэгжилт, төрийн байгууллагуудын эрх бүхий албан тушаалтаны авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагааны чиглэлээр зохион байгуулах ажил үүргийн үр дүн, чанар сайжирч үүрэг хариуцлага нэмэгдэх ач холбогдолтой боллоо.

Урьдчилан сэргийлэх соён гэгээрүүлэх чиглэлээр Булган, Говь-Алтай, Ховд, Увс, Дорноговь аймгийн нийт 52 суманд давхардсан тоогоор 37 ажилтан, албан томилолтоор ажилласан байна. Томилолтын явцад илэрсэн нийтлэг зөрчил дутагдал гаргуулахгүй байх, албан тушаалтныг авлига, албан тушаалын гэмт хэрэг, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, авлигын хор хөнөөлийг нийгэмд ухуулан таниулах зорилгоор бүх шатны холбогдох байгууллагууд, албан тушаалтнуудад 15 зөвлөмж хүргүүлсэн байна.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд төрийн байгууллага, албан тушаалтанд хүлээлгэсэн нийтлэг үүргийн биелэлтийг хангуулах арга хэмжээг хэрэгжүүлэхээр Мөрдөн байцаагчаас гэмт хэрэг гарахад нөлөөлсөн шалтгаан нөхцөлийг арилгуулахаар хүргүүлсэн 14 мэдэгдлийн хуулбарыг, судалгааны хамт хүлээн авч, түүний мөрөөр авч хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө батлан хэрэгжилтийг зохих байдлаар ханган ажиллаж байна. Ингэснээр Сүхбаатар дүүргийн Эрүүл мэндийн нэгдлийн даргын хууль зөрчсөн 5 тушаал, 6 гэрээг хүчингүй болгуулсан байна.

Урьдчилан сэргийлэх соён гэгээрүүлэх хэлтэст төрийн үйлчилгээний хүнд суртал, төрийн албан хаагчийн ёс зүйтэй холбоотой 24 гомдол ирсэнээс, 23 нь хугацаандаа шийдвэрлэгдэж, 1 гомдол шийдвэрлэгдэх шатандаа байна.

Авлигын эсрэг хууль тогтоомжийн зөрчил дутагдлыг арилгуулах ажлын хүрээнд аймаг, сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын болон Тэргүүлэгчдийн тогтоолоор баталсан дүрэм журмыг хүчингүй болгуулахаар 64 албан бичиг хүргүүлж 33 дүрэм журам хүчингүй болгож, 30 албан тушаалтанд хариуцлага тооцуулж, ёс зүйн 15 дүрэмд санал өгсөн байна. 2015 онд томоохон эмнэлгүүд, эрүүл мэндийн төвд ажиллан, авлигын эсрэг хууль тогтоомжийн хэрэгжилтийн байдалтай танилцаж, арга зүйн зөвлөгөө өгөх ажлыг зохион байгуулав.

Соён гэгээрүүлэх чиглэлээр нийт 260 удаагийн сургалт зохион байгуулж, 294 хичээл зааж давхардсан тоогоор 18066 хүнийг хамруулж, Эрүүл мэндийн салбарт “Талархалаа зөв илэрхийлье” аяны хүрээнд тус салбарын 1872 ажилтан, албан хаагчдыг сургалтад хамрууллаа.

ЕБС-ын бага ангид “Туулай хүүгийн адал явдал” гарын авлагыг түгээх аянд нийслэлийн ерөнхий боловсролын 40 гаруй сургуулийн бага ангийн сурагчдыг хамруулан, холбогдох гарын авлага, хэвлэмэл материалыг бэлтгэн тараасан бөгөөд Үүнд:

- “Шударга ёс-бидний тэмүүлэл” сургуулийн багш нарт зориулсан гарын авлага - 1000 хувь;
- “Туулай хүүгийн адал явдал” ЕБС-ийн бага, цэцэрлэгийн ахлах ангийн сурагчдад хичээл заах сургалтын гарын авлага - 1000 хувь;
- “Авлигын эсрэг хууль болон сонирхлын зөрчлийн хууль - 2000 хувь;
- Мэдээллийн ил тод байдал ба мэдэх эрхийн болон Шилэн дансны хууль - 2000 хувь;
- “Өндөр түвшний авлига” VIP 76 сэтгүүлийн дугаар - 3000 хувь;
- ЭЗХАХБ-аас гаргасан “Монгол Улсад хэрэгжиж байгаа авлигын эсрэг шинэчлэл”-ийн тухай үнэлгээний тайлан, АТГ-ын танилцуулга, ажлын хавтас, дэвтэр /англи хэл дээр/ - тус бүр 300 хувь;
- Хөтөлбөрт сургалтад зориулан сонирхлын зөрчлийн хуулийг сурталчилсан ажлын хавтас - 500, дэвтэр - 1000 хувь байна.

Сонирхлын зөрчлийн хуулийн 12 төрлийн хориглолт хязгаарлалтыг таниулах цуврал богино хэмжээний сургалтын видео, Авлигатай тэмцэх газар: орон нутагт нэвтрүүлэг, Сайн засаглалын сайн санаачилгууд нэвтрүүлэг зэрэг видео болон аудио материалуудыг бэлтгэв.

“Шударга нийгмийн төлөө хамтдаа” оюутан залууст чиглэсэн сургалтыг 6 удаа, мөн ЦЕГ-тай хамтран сургагч багшийн сургалтыг 11 дүгээр сард тус тус зохион байгуулсан. Нийт 6 байгууллагад ажиллаж, сургалт сурталчилгаа, арга зүйн удирдлагаар ханган ажиллав.

Авлигын эсрэг олон улсын өдрийг “Шударга нийгмийг хамтдаа бүтээе” уриан дор тэмдэглэн өнгөрүүлж, “Шударга ёсны төлөө 2015” сайн засаглалын сайн санаачилгыг 9 номинациар тодруулж өргөмжлөл гардуулав. Мөн Авлигын эсрэг олон улсын өдрийг угтан 5 төрлийн тэмцээн, уралдааныг зорилтот бүлэгт хандан зарлаж дүгнэв.

Түүнчлэн 2 сэдвээр хэлэлцүүлэг өрнүүлж, Өндөр түвшний авлигын асуудлаар болон төвийн болон орон нутгийн бизнесийн төлөлөлтэй цахим хэлэлцүүлгийг 3 удаа цуврал маягаар зохион байгуулсан болно.

Олон улсын “Стар санаачилга”-тай хамтран “Эрх зүйн харилцан туслалцааны хүсэлтийг боловсруулах ахисан түвшний сургалт”-ыг 30 хүнд зохион байгуулсан.

Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын Зүүн Европ, Төв Азийн авлигын эсрэг сүлжээний Стамбулын авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний Монгол Улсын үнэлгээг хариуцсан багийн гишүүд Монгол Улсад ажиллаж нийт 10 сэдвийн хүрээнд уулзалт зохион байгуулж, сэдэв тус бүрийн чиглэлийн 40 гаруй төрийн байгууллагууд, мэргэжлийн холбоодыг урьж оролцуулсан байна.

УИХ-ын Тамгын газрын “Иргэдийн оролцоотой хууль тогтоох ажиллагааг дэмжих нь” төслийн санхүүжилтээр НҮБ-ын Авлигын эсрэг конвенцийн 2, 5 дугаар бүлгийн хэрэгжилтийн өөрийн үнэлгээг хийлгэх бэлтгэл ажлыг хангах зорилгоор үнэлгээ хийхэд ашигладаг олон улсын “Омнибус” програмыг монгол хэлэнд хөрвүүлэн хамрагдах байгууллагуудын үнэлгээ хариуцан зохион байгуулах ажилтнуудын үйл ажиллагааг эрчимжүүлэх, чадавхижуулах сургалтыг өөрийн байгууллага дээр зохион байгуулж 23 байгууллагын 28 албан хаагч сургалтад хамруулсан бөгөөд НҮБ-ын Авлигын эсрэг Конвенцийн 2, 5 дугаар бүлгийн хэрэгжилтийн тайланг 21 байгууллагаас бичгээр болон цахимаар авч зөвлөх үйлчилгээний багт хүргүүлэн холбогдох мэдээллийг солилцон хамтран ажиллалаа.

Дэлхийн банкны буцалтгүй тусламжаар хэрэгжиж байгаа “Авлигаас урьдчилан сэргийлэх ажиллагаа, хяналт шалгалтыг бэхжүүлэх төсөл”-ийн хүрээнд ХАСХОМ-ийн системд үнэлгээ, дүн шинжилгээ хийх нэмэлт функцыг оруулах, ХАСХОМ-ийн системийн програмын хөгжүүлэлт хийх болон газрын үйл ажиллагаатай холбоотой хууль тогтоомж, бодлогын баримт бичгийг орчуулах ажлыг зохион байгуулсан байна.

Авлигын эсрэг үндэсний стратегийн төслийг намрын чуулганаар УИХ-д өргөн барихтай холбоотой Авлигын эсрэг үндэсний стратегийн төслийн хэлэлцүүлгийг Ерөнхийлөгчийн Тамгын газар, Транспэрэнси интернэшнл Монгол ТББ-тай хамтран зохион байгуулав. Төсөл Хууль зүйн байнгын хороогоор орж дэмжигдэн УИХ-ын нэгдсэн чуулганаар хэлэлцэгдэх гэж байна.

“Нээлттэй нийгэм форум”-ын санхүүжилтээр “Нийгмийн дэвшил эмэгтэйчүүдийн хөдөлгөөн” ТББ-тай хамтран хэлэлцүүлэг зохион байгуулж, “хандив”-тай холбогдох эрх зүйн зохицуулалтын талаар мэдээлэл хийж,

оролцогчдоос “Нийгмийн хариуцлагын гэрээ”, сургууль, цэцэрлэгийн хандивтай холбоотойгоор тавигдсан асуултуудад мэдээлэл өгч оролцов.

УИХ-ын Төрийн байгуулалтын байнгын хороо, “Сонгогчдын боловсрол төв” төрийн бус байгууллагатай хамтран “Сонгуулийн санхүүжилт шинэчлэлийн асуудал” сэдвээр УИХ-ын гишүүд, улс төрийн нам, төрийн болон иргэний нийгмийн байгууллагын төлөөллийн хүрээнд хэлэлцүүлэг зохион байгуулсан.

Баруун гурван аймаг буюу Увс, Баян-Өлгий, Ховд аймгийг хамарсан “Сайн засаглал бүсийн форум”-д оролцсон байна. Мөн “Глоб интернэшнл” ТББ-тай хамтран хүний эрхийн болон ёс зүйн өндөр мэдрэмжтэй, шударга хуульчдыг бэлтгэхэд хувь нэмэр оруулах зорилгоор эрх зүйн чиглэлээр суралцаж буй оюутан залууст авлигын эсрэг боловсрол олгох “Хангай ба түүний нөхөд юу хэлэв?” кино сургалтын хөтөлбөрийг боловсруулсан байна.

Хоёр. Судалгаа, шинжилгээний ажлын чиглэлээр

Авлигын индексийн судалгаа болон Төрийн байгууллагын шударга байдлын судалгааг нэгтгэн, БНСУ-ын Шударга байдлын үнэлгээний аргачлал, арга зүйд тулгуурлан Шударга байдлын үнэлгээний аргачлал, судалгааны удирдамж, асуулгын маягыг Газрын даргын 2015 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн А/129 тоот тушаалаар батлуулан мөрдөж байна. Мөн Шударга байдлын үнэлгээний судалгааны удирдамжид заасны дагуу Шударга байдлын үнэлгээний 2015 оны судалгаанд хамруулах байгууллагын нэрсийг гаргаж газрын даргын 2015 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн А/131 тоот тушаалаар батлуулав. Төрийн байгууллагын шударга байдлын түвшинг үнэлэх 2014 оны судалгааны үр дүнг судалгаанд хамрагдсан байгууллагуудын төлөөлөлд танилцуулах ажлыг зохион байгуулав. Судалгааны үр дүнгийн тайланг хэвлүүлэн олон нийтэд түгээн ажиллав. 2014 оны судалгааны дүнг СЯ, НДЕГ, УБЕГ, Нийгмийн халамж үйлчилгээний төв, ЦЕГ, Замын цагдаа, ХУД, Налайх дүүргийн захиргаа, клиникийн I, III эмнэлгийн ажилтнуудад танилцуулж хэлэлцүүлэг өрнүүлэв.

Улс төр, шүүх, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын талаархи төсөөлллийн 2014 оны судалгааны үр дүнгийн тооцоолол 3.58 гарсан ба судалгааны тайланг боловсруулан хэвлүүлж, олон нийтэд тараасан байна.

ХШДШХ-ээс ХАСХОМ-ийн мэдүүлэг гаргагч 35345 хүний жагсаалтыг авч, энгийн санамсаргүй түүврийн аргаар 1000 төрийн албан хаагчийг сонгон туршилтаар онлайн хэлбэрээр “Survey monkey” программаар асуулгыг хүргүүлж, туршилт судалгааг явуулав. Судалгааг онлайнаар зохион байгуулахын тулд судалгааны

асуулгыг товч байлгах, судалгаанд оролцогчдыг зөв сонгох явдал чухал болох нь харагдсан тул энэ чиглэлийн үйл ажиллагааг зохион байгуулж байна.

Авлигын талаарх төсөөллийн 2015 оны судалгааны мэдээлэл цуглуулах ажлыг хөндлөнгийн байгууллагаар хийлгэхтэй холбоотойгоор 2 багц ажлыг сонгон шалгаруулалт зарлан гүйцэтгүүлж байна.

Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хороотой хамтран Төрийн ордонд зохион байгуулсан “Сонгуулийн санхүүжилт-шинэчлэлийн асуудал” сэдэвт хэлэлцүүлэгт, мөн Зориг сантай хамтран зохион байгуулсан “Ардчилал зуны сургалт хөтөлбөр” сургалтад тус тус оролцож 2014 оны судалгааны дүнг танилцуулав.

“Хүүхдийн шударга байдал-2015” судалгааг цахим хэлбэрээр явуулж байгаатай холбогдуулан судалгааны асуулгыг “Survey monkey” програмд шивж оруулан, судалгааны хамрах хүрээг өргөжүүлэн Монгол Улсын 21 аймаг, 9 дүүргийн Ерөнхий боловсролын сургуулийн 7-11 дүгээр ангийн сурагчдыг хамруулан Хүүхдийн төлөө үндэсний газартай хамтран ажиллаж байна.

Тайлангийн хугацаанд Цагдаагийн байгууллагын хүүхдийн байцаагч нарт “Хүүхдийн шударга байдлын судалгаа”-ны үр дүнгийн талаар танилцуулга хийв.

Цагдаагийн байгууллагын авлига, хүнд суртал болон ашиг сонирхлын зөрчил үүсгэж болзошгүй ажлын байр, албан тушаал, удирдах алба хаагчдын авлигын хандлагыг тодорхойлох судалгааг нийслэлийн 4 дүүрэг, 3 аймгийн цагдаагийн газрын үйл ажиллагааг хамруулан 305 цагдаагийн албан хаагч, 331 иргэнээс асуулга авч зохион байгуулсан бөгөөд дүнг нийслэл, дүүргүүдийн албан хаагчдад мөн судалгааны дүнгээр авлигад өртөх эрсдэл өндөртэй гарсан дүүргийн замын цагдаагийн хэрэг бүртгэгч, байцаагч нарт судалгааны дүнг танилцуулах ажлыг зохион байгуулав.

“Монгол Улсын авлигатай тэмцэх хууль тогтоомжийн хэрэгжилт, авлигын ерөнхий нөхцөл байдал”-ын талаарх, мэдээллийг боловсруулан хэвлүүлж, УИХ-д хүргүүлэв. Энэ удаагийн мэдээллийг улс, аймаг, нийслэл болон салбарын түвшинд бэлтгэсэн бөгөөд танилцуулга мэдээллийг УИХ-ын гишүүд, ОНЗ-ийн гишүүд, бүх яам, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт хүргүүлэв.

Гадаадын хэвлэл, мэдээллийн хэрэгслээр 2013-2014 онд гарсан авлигын талаарх мэдээ, нийтлэлийг нэгтгэн эмхэтгэж, “Дэлхийн улсуудын авлигатай тэмцэх үйл ажиллагаа” товхимол бэлтгэж 1000 ширхэг хэвлүүлэн, ОНЗ болон яам, агентлаг, аймаг, нийслэл, дүүргийн Засаг даргын Тамгын газар, нийслэлийн агентлагуудад хүргэн өгч, байгууллагын цахим хуудсанд байршуулан олон нийтэд хүргэсэн нь бусад улс орнуудын зүгээс авлигатай тэмцэх чиглэлээр хэрэгжүүлж буй

үйл ажиллагааг судлах, авлигын эсрэг мэдээлэл өгөх, улмаар энэ чиглэлийн санал, санаачилгыг нэмэгдүүлэхэд ач холбогдолтой болсон гэж үзэж байна.

Гадаад улс орон, олон улсын байгууллагын туршлагыг судалж, мэдээллээр хангах ажлын хүрээнд Австри, Америкийн Нэгдсэн Улс, Гонконг, Индонез, БНСУ, Сингапур, Малайз, Филиппин, Хятад, Макао, Итали, Камбож, Японы авлигатай тэмцэх үйл ажиллагааны талаар судалж, газрын удирдлагуудад танилцуулан, тэдгээрийг байгууллагын цахим хуудсанд байршуулав.

Ази, номхон далайн орнуудын шударга байдлын сүлжээ “AP-INTACT”, “Транспарэнси Интернэшнл” байгууллагын ил тод байдлын мэдээллийн сүлжээгээр ирүүлсэн авлигын эсрэг үйл ажиллагааны талаарх нийтлэл, үйл явдал, мэдээллийг судлан, 7 хоног бүрээр түүвэрлэн орчуулж, “Гадаад мэдээний тойм” 52 дугаарыг бэлтгэн газрын удирдлага болон хэлтсийн дарга нарт танилцуулж, мэдээг байгууллагын цахим хуудсанд байршуулах, шаардлагатай мэдээллийг олон нийтэд хүргэх ажлыг зохион байгуулж ажиллав.

АТГ-т хүлээн авсан өргөдөл, гомдол, мэдээлэлд сар, улирал, хагас жилийн байдлаар дүн шинжилгээ хийж, танилцуулга бэлтгэн газрын удирдлага болон хэлтсийн дарга нарт танилцуулж, байгууллагын цахим хуудсанд байршуулж ажиллаа.

“Шударга ёс онол арга зүйн цувралын 2014 оны 2, 3 дахь дугаарыг 1000 ширхэг хэвлүүлж, олон нийтэд түгээх ажлыг зохион байгуулж байна.

Авлигатай тэмцэх хариуцлага, шударга ёсыг бэхжүүлэх үндэсний хөтөлбөр батлах тухай УИХ-ын тогтоолын төсөл, хөтөлбөрийн төсөлд Засгийн газраас ирүүлсэн санал болон хэлтэс, албадаас ирүүлсэн саналыг нэгтгэж, холбогдох засвар, өөрчлөлт оруулан, төслийн шинэчилсэн хувилбарыг Ерөнхийлөгчийн тамгын газарт хүргүүлэв.

Төрийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Зөрчлийн тухай, Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, түүний үзэл баримтлал, танилцуулга, Хууль сахиулах ажиллагааны тухай, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай, Мөрдөх албаны тухай, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хохирлын сангийн тухай хуулийн төслүүдэд санал бэлтгэн Хууль зүйн сайдад хүргүүлэв. Түүнчлэн Эрүүгийн байцаан шийтгэх хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Прокурорын байгууллагын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл, Эрүүгийн байцаан шийтгэх хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Прокурорын байгууллагын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай УИХ-ын тогтоолын төсөл, танилцуулга, үзэл баримтлалтай танилцаж, санал бэлтгэн хүргүүлэх ажлыг зохион байгуулав.

НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлөөр 2015 онд хэлэлцүүлэх “Монгол Улс дахь Хүний эрхийн төлөв байдлын талаарх үндэсний 2 дугаар илтгэл”-ийн төсөл, Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтын хэрэгжилтийн талаарх Үндэсний илтгэлийн төсөлд тус тус санал бэлтгэн Сангийн яам, Гадаад хэргийн яам, Хууль зүйн яаманд хүргүүллээ.

Монгол Улсын Засгийн газрын 2013 оны 381 дүгээр тогтоолоор батлагдсан олон улсын “Нээлттэй засгийн түншлэлийн үйл ажиллагааны үндэсний төлөвлөгөө”-ний хэрэгжилтийн явцын тайланг бэлтгэж ЗГХЭГ, “Гэмт хэрэг, хууль сахиулах статистикийн үзүүлэлт”-ийг тооцох аргачлалын төсөлд санал бэлтгэн Үндэсний Статистикийн Хороонд тус тус хүргүүлсэн байна.

Гурав. Хяналт шалгалт дүн шинжилгээний ажлын талаар

Авлигатай тэмцэх газарт 2014 оны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгээ мэдүүлбэл зохих 270 мэдүүлэг гаргагчийн 268 нь хуульд заасан хугацаандаа мэдүүлсэн. 2015 онд шинээр 65 албан тушаалтан томилогдсон бөгөөд 14 албан тушаалтан их хэмжээний өөрчлөлтөө бүртгүүлсэн байна.

Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийг мэдээллээр хангах журмын дагуу нийтийн албан тушаалтнуудын 2014 оны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон, хөрөнгө, орлогын мэдүүлгийг шинэчлэн бүртгэсэн тухай танилцуулах тойм мэдээг бэлтгэж Үндэсний аюулгүй байдлын зөвлөлд, Авлигын эсрэг хуулийн 11 дүгээр зүйлийн 11.5-д заасны дагуу нийтийн албан тушаалтнуудын 2014 оны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон, хөрөнгө, орлогын мэдүүлгийг шинэчлэн бүртгэсэн тухай, бүрдүүлэлтийн тайлангийн нэгдсэн дүнгийн тухай мэдээллийг боловсруулан Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороонд тус тус хүргүүлсэн.

Авлигатай тэмцэх газарт мэдүүлгээ бүртгүүлдэг төрийн өндөр болон тэдгээртэй адилтгах зэрэг зиндаа адилтгах албан тушаалтнууд, Улсын дээд шүүхийн шүүгч, Үндсэн хуулийн цэцийн гишүүн, аймаг, нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн Хурлын дарга, Засаг дарга зэрэг 244 албан тушаалтны Хөрөнгийн орлогын мэдүүлэгт зохих хяналтыг хийж, Авлигын эсрэг хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-т заасан хугацаанд “Төрийн мэдээлэл” сэтгүүлийн 2015.04.17-ны өдрийн №15/876/ дугаарт нийтлүүлсэн, мөн www.xacxom.iaac.mn цахим хуудсанд дээрх албан тушаалтнуудын хөрөнгө, орлогын мэдүүлгийг байршуулж олон нийтэд ил болголоо.

Олон нийтийн вэб сайт /www.xacxom.iaac.mn/-д 2015 оны 12 сарын 15-ны байдлаар 18789 хандалттай байна.

Авлигатай тэмцэх газрын 119 мэдүүлэг гаргагчийн 2014 оны ХАСХОМ-ийг, мөн онд шинээр томилогдсон 23, их хэмжээний өөрчлөлтөө мэдүүлсэн 15 албан тушаалтны мэдүүлгийг цаасан болон цахим хэлбэрээр тус тус бүртгэж авсан байна. Мөн 1 албан тушаалтан “Ашиг сонирхлын зөрчилгүйг илэрхийлсэн, зөрчил үүссэн тухай мэдэгдлийн маягт”-ыг гаргасныг бүртгэж авсан байна.

Авлигатай тэмцэх газарт 2015 онд шинээр томилогдсон 2014 оны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгээ шинэчлэн гаргасан, мэдүүлэг гаргагчдын мэдүүлгийг нэрсийн жагсаалтын хамт Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороонд хүргүүлээ.

Төрийн захиргааны болон нутгийн захиргааны төв 113 байгууллагын мэдүүлгийн бүрдүүлэлтийн 2015 оны тайлан /ХАСХОМ 1,2, 3 болон бичмэл тайлан/ мэдээг цаасаар болон цахим хэлбэрээр гаргуулан авч нэгтгэсэн.

Улсын хэмжээнд 38423 мэдүүлэг гаргагч бүртгэгдсэнээс 38422 мэдүүлэг гаргагч буюу 99,99 хувь нь бүртгүүлсэн. Үүнээс 38421 мэдүүлэг гаргагч хуульд заасан хугацаанд бүртгүүлсэн бол 1 мэдүүлэг гаргагч /ҮОНРТ-ийн Үндэсний зөвлөлийн гишүүн Б.Цэнддоо/ хугацаа хожимдуулсан, 1 мэдүүлэг гаргагч /ҮОНРТ-ийн Үндэсний зөвлөлийн гишүүн Д.Сосорбарам/ мэдүүлгээ гаргаж өгөхөөс татгалзсан байна.

Дээрх 2 мэдүүлэг гаргагчтай холбоотой 2014 оны ХАСХОМ-ийг хуульд заасан хугацаанд гаргуулан тус газарт ирүүлэх, мэдүүлээгүй тохиолдолд Авлигын эсрэг хуульд заасны дагуу хариуцлага тооцох, олон нийтэд мэдээлэх тухай асуудлыг МҮОНРТ-ийн Үндэсний зөвлөл /хувийг Улсын Их Хурлын Тамгын газар/-д албан бичгээр хүргүүлсэн болно.

Албан тушаалтнуудын 2014 оны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийн бүрдүүлэлтийн байдлыг сүүлийн 5 жилийн байдлаар харьцуулж /хүснэгт-1/ үзүүлбэл:

Хүснэгт 1

Үзүүлэлт		2010 оны ХОМ	2011 оны ХОМ	2011 оны ХАСХОМ	2012 оны ХАСХОМ	2013 оны ХАСХОМ	2014 оны ХАСХОМ
Бүртгүүлбэл зохих мэдүүлэг гаргагчийн тоо		56832	58251	45858	47142	51584	38423
Бүртгүүлсэн нийт мэдүүлэг гаргагчийн тоо		56763	58187	45762	47127	51579	38422
Үүнээс	Хугацаандаа мэдүүлсэн	56714	58162	45755	47105	51573	38421
	Хугацаа хожимдуулж мэдүүлсэн	49	25	7	22	6	1

Огт бүртгүүлээгүй мэдүүлэг гаргагчийн тоо		69	64	96	15	5	1
Үүнээс	ИТХ-ын төлөөлөгч	61	50	83	16	1	-
	Бусад	8	14	20	21	10	1
Бүрдүүлэлтийн хувь		99.87	99.89	99.79	99.97	99.99	99.99

Мэдүүлгийн бүрдүүлэлтийн цахим мэдээллийн сангаас Гүйцэтгэх ажлын хэлтсийн хүсэлтийн дагуу 1090, Мөрдөн шалгах хэлтсийн хүсэлтийн дагуу 88, Хяналт шалгалтын албаны хүсэлтийн дагуу 778, бусад байгууллага/шүүх прокурор, цагдаа/-д 26, нийт 1982 мэдүүлэг гаргагчийн 2013, 2014 онуудын хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг гаргаж өгсөн бөгөөд мэдүүлгийг бүртгэж хадгалж буй байгууллагаас нийтийн албан тушаалтнуудын 2007-2014 оны нийт 159 мэдүүлгийг татан авч зохих хэлтэс, албанд хүргүүлсэн байна.

Гадаад хэргийн яам, Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын яам, Хөдөлмөрийн яам, Сангийн яам, Барилга, хот байгуулалтын яам, Эрүүл мэнд, спортын яам, Иргэний нисэхийн ерөнхий газар, Тахарын ерөнхий газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар, Газрын харилцаа, геодоези зурагзүйн газар, Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар, Хөрөнгө оруулалтын газар, Тагнуулын ерөнхий газар, Хил хамгаалах ерөнхий газар, Төрийн өмчийн хороо, Гаалийн ерөнхий газар, Өмнөговь аймгийн ЗДТГ, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн Ажлын алба, Төв аймгийн ИТХ-ын Ажлын алба, Хөвсгөл аймгийн ЗДТГ, Татварын ерөнхий газар, Мал эмнэлэг, үржлийн газар, Хүүхдийн төлөө үндэсний газар, Цөмийн энергийн комиссын Ажлын алба зэрэг 24 байгууллагын мэдүүлгийг бүртгэх, хянах, хадгалах эрх бүхий албан тушаалтнууд 2015 онд шинээр томилогдсон тул цахим програмд бүртгэж, мэдүүлгийн програмын талаар болон эрх бүхий албан тушаалтны үйл ажиллагааны талаар заавар зөвлөгөөг өгч ажилласан.

Эрх бүхий албан тушаалтны үйл ажиллагаанд гарч буй түгээмэл зөрчлүүдийг арилгуулах чиглэлээр мэдүүлгийн бүрдүүлэлтийн 10 гаруй төрлийн үйл ажиллагааг хэрэгжүүлж, хариу ирүүлэх тухай зөвлөмжийг төрийн байгууллагуудад хүргүүлж, зөрчлийг арилгуулсан байна.

Авлигын эсрэг хуулийн 13 дугаар зүйлийн 13.3-д заасны дагуу мэдүүлгийг бүртгэх, хянах, хадгалах эрх бүхий албан тушаалтан /Төрийн өмчийн хорооны харьяа Улаанбаатар Төмөр замын хувь нийлүүлсэн нийгэмлэг, Дархан-Уул аймгийн ЗДТГ, Орхон аймгийн ЗДТГ, Сэлэнгэ аймгийн ЗДТГ, Увс аймгийн ИТХ, ЗДТГ, Ховд аймгийн

ЗДТГ, Говь-Алтай аймгийн ЗДТГ, Хэнтий аймгийн ЗДТГ, Дорнод аймгийн ЗДТГ, Цагдаагийн ерөнхий газар/-ууд нь бие дааж харьяа байгууллага, сумдын албан хаагч нарт мэдүүлгийн талаар сургалт зохион байгуулж, бүх албан хаагчдын хөрөнгө, орлогын мэдүүлэгт бүрэн эрхийнхээ хүрээнд хяналт шалгалтын үйл ажиллагааг явуулж ажиллахад арга зүйн зөвлөгөө өгч ажиллалаа.

“Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргах зарим албан тушаалтны жагсаалт”-ыг шинэчлэх асуудлаар төвийн болон салбар байгууллагын мэдүүлгийг хянах, хадгалах эрх бүхий албан тушаалтнуудаас санал авч нэгтгэх үйл ажиллагааг 2014 онд зохион байгуулан, Монгол Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны 2012 оны 05 дугаар тогтоолоор баталсан “Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийн маягт, түүнийг бүртгэх, хянах, хадгалах журам”, уг журмын 5 дугаар хавсралтаар баталсан “Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргах зарим албан тушаалтны жагсаалт”-ыг шинэчлэн батлуулав. Уг журам, жагсаалтыг шинэчлэн батласан УИХ-ын Хууль зүйн байнгын хорооны 20 дугаар тогтоолыг хүлээн авч мэдүүлгийн бүрдүүлэлтийн програм, байгууллагын цахим хуудас, ЭБАТ-ын Facebook-т цахим хэлбэрээр байршуулан таниулах ажлыг зохион байгуулсан. Мөн мэдүүлгийн бүрдүүлэлтийн ажлын бэлтгэл хангах, авлига, ашиг сонирхлын зөрчил арилгуулах, зөрчилд хариуцлага тооцуулах, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх бусад асуудлаар төрийн захиргааны болон нутгийн захиргааны төв байгууллагуудад 3 удаа, бүх яамдын сайд, 2015 онд шинээр томилогдсон сайдууд болон Улсын их хурлын Тамгын газар, Санхүүгийн зохицуулах хороо, Татварын ерөнхий газар зэрэг нийт 113 байгууллагуудад зөвлөмж хүргүүлж ажилласан байна.

Хууль тогтоомжийн хэрэгжилтийг шалгах ажлын хүрээнд 2015 онд мэдүүлгийн бүрдүүлэлтийн хяналт шалгалтын чиглэлээр ГХЯ, БСШУЯ, БОНХАЖЯ, АУЯ, ХХЕГ, ИХШХЕГ, Оюуны өмчийн газар, Хүүхдийн төлөө үндэсний газар, Архивын ерөнхий газар, нийслэлийн 5 дүүрэг /БЗД, СБД, НД, БНД, БХД/, 12 аймаг /Говь-Алтай, Увс, Булган, Дорноговь, Говьсүмбэр, Дундговь, Өмнөговь, Өвөрхангай, Баянхонгор, Сэлэнгэ, Орхон, Хөвсгөл/-ийн ЗДТГ, тэдгээрийн харьяа 161 байгууллагуудад 2014, 2015 оныг хамруулан шалгалаа.

Хяналт, шалгалтын ажлын төлөвлөгөөний дагуу болон авлигын эсрэг хууль тогтоомж, бүрдүүлэлтийн үйл ажиллагаанд түгээмэл гарч буй зөрчлүүдийг арилгуулах чиглэлээр төрийн байгууллагуудад зөвлөмж хүргүүлсний дагуу хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг хянуулаагүй томилсон 634 албан тушаалтныг чөлөөлүүлж, уг мэдүүлгийг хянуулахаар тус газарт хянуулж, зөрчлийг арилгуулсан

байна. 2015 онд нийт 285 хүнд холбогдох хариуцлага тооцуулсан бөгөөд хуулийн хэрэгжилтийг хангах талаар зохих арга хэмжээг авч ажилласан.

Хариуцлага тооцогдсон байдал /сүүлийн 3 жилийн байдлаар/

№	Хариуцлага тооцуулсан байдал	2013 онд /тоогоор/	2014 онд /тоогоор/	2015 онд /тоогоор/
1	ИТХ-ын Ажлын албаны дэргэдэх ёс зүйн хорооны хурлаар “Анхааруулга”	14	-	129
2	АЭХ-ийн 13.8.1-т заасны дагуу “Сануулах”	33	235	136
3	АЭХ-ийн 13.8.2-т заасны дагуу “Цалингийн хэмжээг бууруулах”	11	20	20
4	АЭХ-ийн 13.8.3-т заасны дагуу “Албан тушаал бууруулах”	5	-	-
5	АЭХ-ийн 13.8.4-т заасны дагуу “Ажлаас халах”	1	3	-
6	Хариуцлага тооцогдсон эрх бүхий албан тушаалтан /ЭБАТ-аас чөлөөлсөн/	3	2	-
	Нийт	67	260	285

Хяналт шалгалтаар хийсэн ажил /сүүлийн 3 жилийн байдлаар/

№	Хяналт шалгалтаар хийгдсэн ажил	2013 онд /тоогоор/	2014 онд /тоогоор/	2015 онд /тоогоор/
1	Шалгагдсан байгууллага	73	76	161
2	Хянасан ХАСХОМ-ийн тоо	2267	2528	3030
3	Нарийвчлан шалгуулахаар Хяналт шалгалтын албанд шилжүүлсэн	134	122	135
4	Бүрдүүлэлтийн хяналтаар хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг хянуулаагүй томилогдсон зөрчилтэй. Үүнээс:	699	1512	768
	Урьдчилсан мэдүүлэг хянуулаагүй томилогдсон албан тушаалтнуудыг чөлөөлж, түдгэлзүүлэн урьдчилсан мэдүүлгийг хянуулах арга хэмжээ авсан.	277 /39.6 хувь/	1272 /84.1 хувь/	634 /84.1 хувь/

2014 оны мэдүүлгээ шинэчлэн гаргасан мэдүүлэг гаргагчдын ангилал зэрэглэлийн судалгааг нэгтгэн гаргасан. Үүнд:


Үзүүлэлт	ТЗ	ТТ	УТ	ТҮ	ТӨХЭ	ТББ	ТӨАТ	Бусад	Нийт
----------	----	----	----	----	------	-----	------	-------	------

Тоо	11548	11273	7686	4237	2258	45	243	1133	38423
Хувь	30,05%	29,34%	20%	11,03%	5,88%	0,12%	0,63%	2,95%	100%

Нийт мэдүүлэг гаргагчийн 15970 буюу 41,56 хувь нь Улаанбаатар хотод байгаа бол 22453 буюу 58,44 хувь нь орон нутагт байна.

Өнгөрсөн оны бүрдүүлэлтээр 51854 мэдүүлэг гаргагч бүртгэгдсэн ба энэ жилийн хувьд мэдүүлэг гаргагчдын тоо **13161**-ээр буурсан нь Монгол Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны 20 дугаар тогтоолоор “Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргах зарим албан тушаалтны жагсаалт”-ыг шинэчлэн баталж, төрийн захиргааны болон улс төрийн, төрийн тусгай, төрийн үйлчилгээний албаны удирдах албан тушаалтнуудаас зарим мэдүүлэг гаргагчийг хассантай холбоотой байна.

Төрийн захиргааны болон нутгийн захиргааны байгууллагад ажиллаж буй эрх бүхий албан тушаалтнуудын судалгаагаар **1671** эрх бүхий албан тушаалтан бүртгэгдсэн. Үүнээс төрийн захиргааны болон нутгийн захиргааны төв байгууллагын 113 байгууллагад **121** эрх бүхий албан тушаалтан, салбар нэгжийн байгууллагуудад **1550** эрх бүхий албан тушаалтан байна.



Нийт эрх бүхий албан тушаалтны 23 хувь нь нийслэлд, 77 хувь нь орон нутагт байх ба эрх бүхий албан тушаалтнуудын **409** буюу **24.5** хувь нь 2014 оны 01 дүгээр сарын 01-нээс 12 дугаар сарын 31-ний хооронд шинээр томилогдсон байна.

Мэдүүлгийн системд тулгуурлан төрийн захиргааны төв байгууллага болох яам, агентлагууд, түүний харьяа салбар нэгжийн 34-н байгууллагын удирдах 3000

орчим албан тушаалтнуудыг хянаж судлахад хяналтын бүртгэлийн дүнгээр нийт **16** яамдаас Зам тээврийн яам, Хүнс, хөдөө, аж ахуйн яамдаас бусад **14** яамд, түүний харьяа байгууллагын **154** удирдах албан тушаалтан Авлигатай тэмцэх газарт уг мэдүүлгийг хянуулаагүй томилогдсон бөгөөд уг асуудлаар холбогдох яамдын сайдуудад 2015 оны 6-р сарын 17-ны өдрийн 01/4252 тоот албан бичгээр зөрчлийг арилгаж, хууль хэрэгжүүлэх асуудлаар хугацаатай үүрэг чиглэл өгч ажилласны дүнд 90 гаруй хувь нь ХАСУМ-ээ хянуулж, зөрчлөө арилгасан байна.

Хяналт шалгалтын албанаас **“илт ашиг сонирхлын зөрчилтэй”** гэсэн дүгнэлт хүргүүлсэн холбогдох 196 албан тушаалтнууд нь уг ажлын байран дээрээ томилогдон ажиллаж байгаа эсэхийг тодруулахаар шаардлагатай мэдээллийг цахим мэдүүлгийн сангаас нягталж судалгаа хийгдэж байна. Судалгааны урьдчилсан танилцуулгаар тухайн хянуулсан албан тушаал дээрээ илт ашиг сонирхлын зөрчилтэй гэсэн АТГ-ын дүгнэлтийг хэрэгжүүлэхгүй, хууль зөрчин томилогдон ажиллаж байгаа 26 албан тушаалтан байна. Уг зөрчлийг арилгуулж, хэрэгжүүлэх асуудлаар холбогдох байгууллага, албан тушаалтанд хандсан байна.

Цахим системд бүртгэлтэй 35000 гаруй албан тушаалтнуудын хүрээнд хувийн ашиг сонирхлын асуудлын тухайд нийтийн албанд ажиллаж байгаа гэр бүлийн гишүүд /эхнэр, нөхөр/-ийн мэдээлэл ба хамаарал бүхий этгээдийн тоон мэдээлэл, мөн түүнчлэн 2013-2014 оны ХАСХОМ-ийн хөрөнгө, орлогын дүнгийн мэдээллээс орлогын төрлөөр ангилан орон сууц, тээврийн хэрэгсэл, зээл, хадгаламж, компани, мал, газар тус бүрээр нийт дүнг илэрхийлэх гэсэн 2 төрлийн судалгааг гаргасан байна.

ХАСХОМ системээс мэдүүлэг гаргагч болон гэр бүлийн гишүүдийн хөрөнгө, орлогоор шүүлт хийж алдаа зөрчлийг шүүж анхааруулах, ашиг сонирхлын зөрчлийн хэв шинжийн талаарх мэдээллийг харуулах боломжтой эсэх талаар мэдүүлэг гаргагчийн хөрөнгө, орлогын судалгаа, Мэдүүлэг гаргагчийн гэр бүлийн гишүүдийн талаар хийгдсэн судалгаа болон Мэдүүлэг гаргагчийн тоон судалгааг тус тус хийсэн байна.

2015 онд нийт 122 байгууллагын 884 эрх бүхий албан тушаалтан, 8805 мэдүүлэг гаргагч, 448 удирдах ажилтан, 10137 хүн /давхардсан тоогоор/-ийг хамруулсан сургалтыг зохион байгуулж ажилласан байна.

№	Сургалтад оролцогчид	2013 он	2014 он	2015 он
1.	Мэдүүлэг гаргагч албан тушаалтан	9531	6568	8805

2.	Мэдүүлгийг бүртгэх, хянах, хадгалах эрх бүхий албан тушаалтан	1436	2130	884
3.	Удирдах ажилтан			448
	Нийт	10967	8553	10137

Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлгээ гаргах хуулийн хугацааг сануулсан сурталчилгааны баннерыг 2015 оны 01 дүгээр сарын 19-ний өдрөөс эхлэн “Өнөөдөр сонин”, “Зууны мэдээ” зэрэг өдөр тутмын сонин, www.zaluu.com, www.news.mn цахим сайтуудад, мөн хуулийн хугацаа сануулсан, цахим бүрдүүлэлтийг сурталчилсан видео сурталчилгаа /шторк/-г МҮОНТ, 25 дугаар суваг, UBS зэрэг телевизээр 2015 оны 02 дугаар сарын 14-нийг дуустал нэвтрүүлсэн бөгөөд сурталчилгааны цацалтад хяналт тавьж ажиллалаа.

Мэдүүлгийн бүрдүүлэлтийн үеэр төрийн өмчит 10 компанийн удирдах ажилтнуудад орон нутагт Багануур, Орхон аймагт очиж сургалт зохион байгуулснаас гадна нийслэлд байрлах төрийн өмчит 8 байгууллагад зохион байгуулсан. Мөн БХБЯ, ХЯ, ОБЕГ, ЦЕГ, ТӨХ, УБЕГ, ИХШХЕГ, Нийслэлийн ЗДТГ зэрэг байгууллагуудын цахим хуудсанд баннер, шторкийг байршуулж сурталчилсан.

Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлгийн бүрдүүлэлтийн явц байдал, УИХ-ын ХЗБХ-ны 05 тогтоолын нэмэлт өөрчлөлт, бүрдүүлэлтийн дүн мэдээний талаар “Ийгл” /2 удаа/, SBN /3 удаа/, MNC, NTV, TV-9, UBS зэрэг телевиз болон Монголын үндэсний радиогийн Хурд агентлаг, Зууны мэдээ, Монголын үнэн, Өнөөдөр, Засгийн газрын мэдээ сонин, www.zaluu.com, www.news.mn, www.iaac.mn цахим сайтуудаар мэдээллийг өгч ажилласан.

Эрх бүхий албан тушаалтнуудад зориулсан, харилцан мэдээ, мэдээлэл, туршлага солилцох зорилготой Facebook-ийг тогтмол ажиллуулж байгаа бөгөөд одоогоор 603 гишүүнтэй байна.

Тайлант хугацаанд “Нийтийн албан тушаалтнуудад зориулсан гарын авлага”-ыг шинэчлэн боловсруулж 20000, урьдчилсан мэдүүлэг, мэдэгдэл, тайлбар, их хэмжээ, хуулийн хугацаа сануулсан 4 төрлийн зурагт хуудсыг 44000 “Эрх бүхий албан тушаалтнуудад зориулсан гарын авлага” /шинэчилсэн 5 дахь хэвлэл/-ыг шинэчлэн боловсруулж 2350штус тус хэвлүүлснээс нийтийн албан тушаалтан нарт зориулсан гарын авлага 21753, эрх бүхий албан тушаалтан нарт зориулсан гарын авлага 1105, 4 төрлийн сурталчилгааны плакат 9445 ширхэгийг тус тус тараагдаж, нийтэд түгээлээ.

2015 оны 2 дугаар улиралд 12 аймагт мэдүүлгийн бүрдүүлэлтийн хяналтаас гадна хууль тогтоомжийг сурталчлах чиглэлээр ажиллаж, тэнд зохион байгуулсан

сургалтад 2290 мэдүүлэг гаргагч, 680 ЭБАТ, 437 удирдах ажилтан, нийт 3407 албан тушаалтан оролцжээ.

ХАСХОМ-ийн мэдээллийн системд бүртгэлтэй бүх мэдүүлэг гаргагчдын 2014 оны ХАСХОМ-ийн эрхийг нээсэн.

Төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны 113 байгууллагын эрх бүхий албан тушаалтнуудын үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллаж байгаа ба мэдүүлгийн бүрдүүлэлтийн програмын “ЭБАТ” цэсний “Цаасаар ирүүлснийг бүртгэх” “Урьдчилсан мэдүүлгийн бүртгэл”, “Мэдэгдэл, тайлбарын бүртгэл”-үүдийг хийлгүүлсэн байна.

Мэдүүлгийн бүрдүүлэлтийн програмд байгаа 2014 оны цахим мэдүүлгийг байгууллага бүрийн бүрдүүлэлтийн тайлан мэдээтэй тулган хянаж, ажилтан нэг бүрээр судалгаа гаргуулж нэгтгэсэн.

“Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийн мэдээллийн систем”-ийг гүйцэтгэсэн “Axis sistem” ХХК-тэй засвар үйлчилгээ үзүүлэх ажлын гэрээг 1 жилийн хугацаатай байгуулсан.

Цахим програмд 2014 оны сүүлээр хийгдсэн Засгийн газрын бүтцийн өөрчлөлтэй холбоотой зарим байгууллагуудын өөрчлөлт, хөдөлгөөнийг бүртгэж оруулсан ба мэдүүлэг гаргагч нарыг шилжүүлэх ажлыг хийж гүйцэтгэсэн.

Тайлант хугацаанд “Хулгайлагдсан эд хөрөнгийг буцаан олгох” чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг Олон улсын байгууллага “Стар санаачлага”-ын дэмжлэгтэй Дэлхийн банкны санхүүжилтээр хэрэгжиж байгаа төслийн гадаадын зөвлөхөд ХАСХОМ-ын цахим програм хангамж, бүрдүүлэлтийн үйл ажиллагааны талаар танилцуулах, мэдээлэл өгөх, уулзалт зохион байгуулах зэргээр хамтран ажилласан байна.


Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө, орлогын мэдүүлгийн 2015 оны төлөвлөгөөт хяналт шалгалтын хүрээнд СХД, ЧД, БЗД-ийн ӨГХА, Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар, НДЕГ, УБЕГ, Өвөрхангай, Увс, Говь-Алтай аймгийн болон Нийслэлийн СБД, БЗД, Налайх дүүргийн ИТХ, ЗДТГ, Эрчим хүчний зохицуулах хороо, Харилцаа холбооны зохицуулах хороо, ХХЕГ, НӨХГ, ЕТГ, ИХШХЕГ-ын албан тушаалтнуудын ХАСХОМ-ийг шалгаж, шалгалтын дүн, илэрсэн зөрчлийг арилгуулах талаар холбогдох албан тушаалтанд албан бичиг хүргүүлж биелэлтийг тооцон ажилласан. 2015 онд төлөвлөсөн бүх байгууллагуудыг бүрэн хамруулж шалгасан ба нэмэлт төлөвлөгөөгөөр 4 байгууллагын албан тушаалтнуудын ХАСХОМ-ийг хянан шалгасан байна.

2015 онд нийт **552** албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг хянан шалгахаар хүлээн авснаас **523** мэдүүлгийг

шалгаж дууссан ба улирлын эцэст үлдэгдлээр **29** албан тушаалтны мэдүүлгийг шалгаж байна.

Тайлант онд шалгасан ХАСХОМ-ийн тоо 2014 оныхоос 73-аар буюу 16,2% өссөн байна. 2015 онд шалгасан нийт мэдүүлгийн **453** буюу 86,6%-ийг төлөвлөгөөт хяналт шалгалтаар, **53** буюу 10,1%-ийг иргэний гомдол, мэдээллээр, **17** буюу 3,32%-ийг тус газрын МШХ-ийн хүсэлтээр тус тус шалгасан байна.

Мэдүүлгийн хяналт шалгалтын бүтцийг өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулж үзүүлбэл:




2015 онд хийсэн мэдүүлгийн хяналт шалгалтын ажлын үндсэн үзүүлэлтийг өнгөрсөн оны мөн үеийнхтэй харьцуулж үзүүлбэл:

Д/д	Үзүүлэлт	2014 он	2015 он	Хувь	Өөрчлөлт
1	Нийт шалгасан мэдүүлгийн тоо	450	523	116,2	73
2	Хугацаанд нь шалгасан мэдүүлгийн тоо	440	514	116,8	75
3	60-аас дээш хоногт шалгасан мэдүүлгийн тоо	10	9		-1
4	Мэдүүлгийг журамд заасан хугацаанд шалгасан үзүүлэлт	97,8 хувь	98,3 хувь	100,5	0,5


2015 онд шалгасан нийт мэдүүлгийн 98,3%-ийг хяналт шалгалтын журамд заасан хугацаанд шалгаж дууссан ба мэдүүлгийг хугацаанд хянах ажлын үзүүлэлт өмнөх оныхоос 100,5% өссөн байна.

Хөрөнгө, орлогын мэдүүлгийн хяналт шалгалтын үр дүнгийн байдал:



Мэдүүлгийн хяналт шалгалтад хамрагдсан албан тушаалтнуудын тоо 2015 онд өмнөх онтой харьцуулбал 16,8 хувиар, хөрөнгө, орлогоо худал мэдүүлсэн албан тушаалтны тоо 6,5 хувиар тус тус өссөн байна. Мэдүүлгийн хяналт шалгалтаар хөрөнгө, орлогоо үнэн зөв мэдүүлсэн албан тушаалтны тоо 2015 онд өмнөх оныхоос 39-өөр буюу 19,5 хувиар нэмэгдсэн байна. Харин зөрчлийн дүн нь хариуцлага тооцуулахаар хэмжээнд хүрээгүй буюу зөрчлийг нь өөрт нь анхааруулсан албан тушаалтны тоо өмнөх онтой харьцуулбал 43-аар буюу 30,4 хувиар нэмэгджээ.

Мэдүүлгийн хяналт шалгалтаар илэрсэн зөрчлийн шалтгаан:



Тайлант хугацаанд шалгахаар хүлээн авсан **552** албан тушаалтныг эрхэлж буй албан тушаалаар нь ангилбал, 52,7 хувь буюу 293 нь удирдах албан тушаалтан, 43,3 хувь буюу 249 нь гүйцэтгэх албан тушаалтан, 4 хувь буюу 10 нь бусад албан тушаалтан байна. Харин албан тушаалын ангиллаар нь авч үзвэл, төрийн захиргааны албан тушаалтан 361, төрийн тусгай 27, улс төрийн албан тушаалтан 47, төрийн үйлчилгээ 49, төрийн өмчит үйлдвэрийн газрын 16, бусад албан тушаалтан 52 байна. Эндээс үзвэл, нийт шалгагдах албан тушаалтны 65,3 хувийг төрийн захиргааны албан тушаалтнууд эзэлсэн байна.

2015 онд иргэн, аж ахуйн нэгж байгууллагаас ирүүлсэн албан тушаалтны авлига, ашиг сонирхлын зөрчлийг шалгуулахаар хандсан нийт **341** өргөдөл, гомдол, мэдээллийг /цаашид ӨГМ гэх/ хүлээн авснаас тайлант хугацаанд **317** ӨГМ-ийг хянан шийдвэрлэж, **24** ӨГМ үлдэгдлээр хянагдаж байна. Тайлант хугацаанд хянан шийдвэрлэсэн ӨГМ-ийг өнгөрсөн оны мөн үеийнхтэй харьцуулахад хүлээн авсан

ӨГМ- нь 24-ээр буюу **7,5** хувиар, хянан шийдвэрлэсэн ӨГМ нь 34-ээр буюу **12,1** хувиар тус тус нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

Хянан шийдвэрлэсэн **317** ӨГМ-ээс **263** буюу 77.1 хувийг хуулийн хугацаанд буюу 30 хоногт, **54** буюу 15.9 хувийг хугацаа сунгаж хянан шийдвэрлэсэн нь өнгөрсөн оны мөн үеийнхтэй харьцуулахад хугацаа сунгаж шийдвэрлэсэн байдал нь **7,5** хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Хүлээн авсан нийт ӨГМ-ийн **242** буюу 70.9 хувийг хувь хүн, иргэнээс, **61** буюу 17.8 хувийг төрийн байгууллага, төрийн өмчит компани, аж ахуйн нэгжээс, **13** буюу 3.8 хувийг бусад байгууллагаас, **25** буюу 7.4 хувийг нэр хаяг нь тодорхойгүй гомдол, мэдээлэл эзэлж байна. Мөн Хяналт шалгалтаар тогтоогдсон нөхцөл байдлын талаар нийт гомдол гаргагч нарт хариуг хүргүүлсэн бөгөөд **73** хувь-д нь албан бичгээр, **27** хувьд нь амаар, утсаар, цахим сүлжээгээр мэдэгдсэн байна.

Графикаар үзүүлэхэд:



ХШДШ-ний чиглэлээр 2013 оноос албаны эрх мэдлээ урвуулсан, хэтрүүлсэн, бусдад давуу байдал олгосон асуудал нь нийт гомдлын ихээхэн буюу **23,5** хувийг эзэлж байсан бол 2015 онд ашиг сонирхлын зөрчилтэй холбоотой буюу албан тушаалтанд тавигдах хориглолт, хязгаарлалтыг зөрчиж ашиг сонирхлын зөрчилтэй шийдвэр гаргасан нь нийт гомдлын **31** хувийг, хууль бус томилгоотой асуудал нь нийт гомдлын **23** хувийг тус тус эзэлсэн байна.

Зөрчлийн шинж чанар	2013 он 311 гомдол	2014 он 317 гомдол	2015 оны 341 гомдол
Албаны эрх мэдлээ урвуулсан, хэтрүүлсэн	23,5%	20%	19,6%
Хууль бус шийдвэр гаргаж бусдад давуу байдал олгосон	20,5%	17%	16,4%
Ашиг сонирхлын зөрчил болон сонирхлын зөрчилтэй шийдвэр гаргасан	21,5%	27%	31%
Албан тушаалтны хөрөнгө, орлогын мэдүүлгийг шалгуулах болон үндэслэлгүйгээр хөрөнгөжсөн	9,0%	10%	8%
Хууль бус томилгоо	16,2%	21%	23%
Бусад	9,3%	5%	2%

Хянан шийдвэрлэсэн **317** ӨГМ-ээс албан тушаалтны буруутай үйл ажиллагааг илрүүлж, хариуцлага тооцуулахаар шийдвэрлэсэн нь 69 буюу **21.8** хувийг, хууль бус шийдвэрийг хүчингүй болгох, хуулийн хэрэгжилтийг хангаж зөрчлийг арилгуулахаар эрх бүхий байгууллага албан тушаалтанд анхааруулж, албан шаардлага хүргүүлсэн нь 103 буюу **32.8** хувийг, төрийн байгууллагад харъяаллын дагуу шилжүүлсэн нь 35 буюу **10.8** хувийг, гомдолд дурдсан асуудал нь тогтоогдоогүй буюу зөрчил илрээгүй нь 83 буюу **26.2** хувийг, гэмт хэргийн шинжтэй зөрчлийг шалгуулахаар Мөрдөн шалгах хэлтэс болон Цагдаагийн байгууллагад харъяаллын дагуу шилжүүлсэн 9 буюу **1.6** хувийг, бусад 22 буюу **6.8** хувийг тус тус эзэлсэн байна.

Хянан шийдвэрлэсэн нийт ӨГМ-ийн **54,2** хувь буюу **172** ӨГМ-ийн зөрчлийг тогтоож зөрчил гаргасан албан тушаалтанд хариуцлага тооцуулах, хууль бус тушаал, шийдвэрийг хүчингүй болгох арга хэмжээ авч ажилласан байна.

Иргэн, аж ахуйн нэгж байгууллагаас ирүүлсэн ӨГМ-ийн **29** хувийг төрийн захиргааны албан тушаалтан, **16** хувийг төрийн тусгай албан тушаалтан, **18** хувийг төрийн улс төрийн албанд (сум, дүүргийн Засаг дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга, Засаг даргын орлогч), **19** хувийг төрийн үйлчилгээний удирдах албан тушаалтан (боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээ), **11** хувийг төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн удирдах албан тушаалтан, **2** хувийг төрийн өндөр албан тушаалтан, **5** хувийг бусад албан тушаалтан эзэлж байна.

ӨГМ-ийн **18** хувь нь засаг, захиргааны нэгжийн удирдлагын асуудалд холбогдох, **12** хувь нь төрийн өмчийн удирдлага, санхүүгийн асуудал, **9,6** хувь нь боловсролын асуудал, **5,6** хувь нь газрын харилцааны асуудал, **4.7** хувь нь эрүүл мэндийн асуудал, **4.2** хувь нь төрийн худалдан авах ажиллагаа, тендерийн асуудалд холбогдож өндөр хувиудыг эзэлсэн байна.

Тайлант хугацаанд хүлээж авсан нийт ӨГМ-ийн **143** буюу **42** хувийг нийслэл хотоос, **198** буюу **58** хувийг хөдөө, орон нутгаас ирүүлсэн төдийгүй 2015 оны тайлант хугацаанд Архангай, Баян-Өлгий, Булган аймгийн иргэдээс ӨГМ түлхүү ирүүлсэн байна.

2015 оны тайлант хугацаанд Нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн нийт **8283** этгээдийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг хүлээн авснаас **8119** этгээдийн мэдүүлгийг хуулийн хугацаанд хянаж, холбогдох байгууллагуудад хариуг хүргүүлсэн, **164** нэр дэвшигчийн мэдүүлэг үлдэгдлээр хянагдаж байна.

Хяналт шалгалтаар ашиг сонирхлын зөрчил үүсэж болохуйц нөхцөл байдлыг тогтоож анхааруулсан нь **279**, ажлын байранд тавигдах шаардлага, шалгуур үзүүлэлтийг хангаагүй болон Төрийн албаны тухай хуулийг зөрчсөнийг тогтоож анхааруулсан нь **163**, хууль, журамд заасан шаардлага хангаагүй үндэслэлээр



буцаасан нь **706**, тухайн албан үүргийг гүйцэтгэхэд илт ашиг сонирхлын зөрчил үүссэн **38** нэр дэвшигч байгааг тогтоож шийдвэрлэсэн байна.

Хариуцлага тооцуулсан байдал: Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах чиг үүргийн хүрээнд зөрчил гаргасан нийт **274** албан тушаалтанд хуулийн дагуу хариуцлага тооцуулж шийдвэрлэсэн байна.

Хариуцлага тооцуулсан байдал /шалгалтын төрлөөр/:

Д/д	Хариуцлагын төрөл	Шалгалтын төрлөөр,			Хариуцлага тооцуулсан албан тушаалтны тоо, бүгд
		ХАСМХОМ-ийн хяналт шалгалтаар	Өргөдөл, гомдлын хяналт шалгалтаар	ХАСМХОМ-ийн бүрдүүлэлтийн хяналтаар	
1	Сануулсан	19	12	136	167
2	Цалинг бууруулсан	26	23	20	69
3	Албан тушаал бууруулсан	-	2	-	2
4	Ажлаас халсан	2	19	-	21
5	Бусад	-	15	-	15
	Дүн	47	71	156	274

2015 оны тайлант хугацаанд зөрчил гаргасан нийт **274** албан тушаалтанд сахилгын арга хэмжээ авахуулж, хариуцлага тооцуулсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал **96**-гаар бага байгаа хэдий ч зөрчлийг арилгах, хууль бус тушаал шийдвэрийг хүчингүй болгуулах зэрэг арга хэмжээг түлхүү авч хэрэгжүүлсэн байна.



Дөрөв. Мөрдөн шалгах ажлын чиглэлээр

Мөрдөн шалгах хэлтэс нь хуулиар хүлээсэн чиг үүрэг, 2015 онд дэвшүүлсэн зорилт, жилийн болон улирлын үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгасан ажлыг хэрэгжүүлж ажиллалаа.

Хэлтэс, албаны дарга мэргэжлийн удирдлагаар, газрын удирдлага зохион байгуулалтын болон бусад удирдлагаар хангаж, гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээлэл, эрүүгийн хэрэг нэг бүрийн мөрдөн байцаалтын ажиллагааг шуурхай гүйцэтгүүлэхэд чиглэсэн мөрдөн байцаагчдын ажлын хэсгээр шалгалт явуулах зохион байгуулалтын хэлбэрийг дэмжиж ажилласан.

Тайлангийн хугацаанд нийт 1027 гомдол, мэдээлэл хүлээн авснаас гэмт хэргийн шинжтэй 428 гомдол, мэдээлэл бүртгэгдсэн нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 70-аар буюу 14.0 хувиар буурсан байна.

Гэмт хэргийн шинжтэй 2014 оны үлдэгдэл 12 гомдол, шинээр хүлээн авсан 428 гомдол нийт 440 гомдол, мэдээллийг хянан үзсэнээс 92 гомдол, мэдээлэл буюу 20.9 хувьд эрүүгийн хэрэг үүсгэсэн нь өмнөх оны мөн үеийнхээс 3.7 хувиар өссөн, 265 гомдол, мэдээлэл буюу 60.2 хувьд эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзах санал гаргасан нь өмнөх оны мөн үеийнхээс 2.3 хувиар буурсан, 70 гомдол, мэдээлэл буюу 15.9 хувийг харьяаллын дагуу шилжүүлэх саналтайгаар прокурорт шилжүүлсэн нь өмнөх оны мөн үеийнхээс 1.5 хувиар буурсан бөгөөд ажиллагаанд 13 гомдол, мэдээллийн үлдэгдэлтэй, шийдвэрлэлт 97.1 хувьтай байна.

Иргэд, байгууллагаас ирүүлсэн гомдол, мэдээллийг агуулга, холбогдох байгууллага, салбараар нь авч үзвэл нийтийн алба, төрийн албаны үйл ажиллагаанд хамаарах 375 гомдол, мэдээллээс төрийн улс төрийн албанд хамаарах 88, төрийн захиргааны албанд хамаарах 169, төрийн тусгай албанд хамаарах 61, төрийн үйлчилгээний албанд хамаарах 57 гомдол, мэдээлэл, бусад салбарт хамаарах 65 гомдол, мэдээллээс хувийн хэвшлийн үйл ажиллагаанд хамаарах 33, улс төрийн намын үйл ажиллагаанд хамаарах 2, төрийн бус байгууллагын үйл ажиллагаанд хамаарах 10, бусад 20 гомдол, мэдээлэл шалгагджээ.

Эдгээр гомдол, мэдээллийг хүлээн авсан хэлбэрээр нь ангилбал албан бичгээр 192, шуудангаар 85, цахим шуудан, вэб сайтаар 8, биечлэн 147, утсаар 6, факсаар 2 гомдол, мэдээлэл тус тус ирсэн байна.

Нийт шалгасан гомдол, мэдээллийн 277 буюу 62.9 хувь нь Улаанбаатар хотын, 163 буюу 37.1 хувь нь орон нутгийн харьяалалтай байна.

Тайлангийн хугацаанд хуульд заасан харьяаллын 345 үйлдэл, 410 холбогдогчтой 238 эрүүгийн хэрэгт мөрдөн байцаалтын ажиллагаа явуулсан.

Мөрдөн байцаалт явуулсан нийт хэргийг Эрүүгийн хуулийн зүйл, хэсгээр ангилбал:

- төрийн албан тушаалтан албаны эрх мэдэл буюу албан тушаалын байдлаа урвуулах 103 буюу 21.7 хувь,
- төрийн албан тушаалтан эрх мэдлээ хэтрүүлэх 35 буюу 7.4 хувь,
- төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн албан тушаалтан эрх мэдлээ урвуулах 36 буюу 7.6 хувь,
- төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн албан тушаалтан эрх мэдлээ хэтрүүлэх 13 буюу 2.7 хувь,
- хээл хахууль авах 81 буюу 17.1 хувь,
- хээл хахууль өгөх 65 буюу 13.7 хувь,
- хээл хахуульд зуучлах 15 буюу 3.2 хувь,
- төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах 11 буюу 2.3 хувь,
- хууль бусаар хөрөнгөжих 7 буюу 1.5 хувь,
- мөнгө угаах 6 буюу 1.3 хувь, бусад хэрэг 103 буюу 21.7 хувийг эзэлж байна.

Зүйлчлэлийг өмнөх оны мөн үетэй харьцуулбал төрийн албан тушаалтан албаны эрх мэдэл буюу албан тушаалын байдлаа урвуулах 16 хэргээр буюу 18.4 хувь, төрийн албан тушаалтан эрх мэдлээ хэтрүүлэх 3 хэргээр буюу 9.4 хувь, төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн албан тушаалтан эрх мэдлээ урвуулах 16 хэргээр буюу 80 хувь, төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн албан тушаалтан эрх мэдлээ хэтрүүлэх 5 хэргээр буюу 62.5 хувь, хээл хахууль авах 26 хэргээр буюу 47.3 хувь, хээл хахууль өгөх 14 хэргээр буюу 27.4 хувь, хээл хахууль зуучлах 4 хэргээр буюу 36.4 хувиар тус тус өсч, төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах 7 хэргээр буюу 38.8 хувь, бусад хэрэг 18.3 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Мөрдөн шалгасан эрүүгийн хэргийн шийдвэрлэлтийг авч үзвэл 55 хэргийг буюу нийт шалгасан хэргийн 23.1 хувийг яллах дүгнэлт үйлдүүлэхээр, 50 хэргийг буюу 21.1 хувийг хэрэгсэхгүй болгох саналтайгаар, 30 хэргийг буюу 12.7 хувийг харьяаллын дагуу шилжүүлэх, 13 хэргийн мөрдөн байцаалтын ажиллагааг түдгэлзүүлэх саналтайгаар прокурорт шилжүүлж, 28 хэргийг буюу 11.7 хувийг өөр эрүүгийн хэрэгт нэгтгэж, 62 эрүүгийн хэргийн үлдэгдэлтэй мөрдөн байцаалтын ажиллагаа хийгдлээ.

Өмнөх оны мөн үетэй харьцуулахад мөрдөн шалгасан хэрэг 0.8 хувиар буурсан, 1 мөрдөн байцаагчийн хянан үзсэн гомдол, мэдээлэл 1.7-оор буурч, мөрдөн байцаалт явуулсан эрүүгийн хэрэг 0.5 хувиар өссөн дүнтэй ажиллалаа.

Мөрдөн шалгасан хэргийн 163 хэргийг буюу 68.5 хувийг шийдвэрлэсэн, хуулийн анхны хугацаанд хэрэг шийдвэрлэлт 37.4 хувьтай байна.

Хэрэгсэхгүй болгосон 50 хэргээс 14 хэргийг харьяаллын дагуу хүлээн авсан, 35 эрүүгийн хэргийг тус хэлтсийн мөрдөн байцаагч нар гомдол, мэдээллээр хүлээн авч эрүүгийн хэрэг үүсгэж шалгаснаас хөөн хэлэлцэх хугацаа дууссан үндэслэлээр 4 хэргийг, гэмт хэрэг үйлдсэн нь нотлогдоогүй үндэслэлээр 4 хэргийг, гэмт хэрэг нь нийгэмд аюултай шинж чанараа алдсан үндэслэлээр 1 хэргийг, Өршөөл үзүүлэх тухай хуулиар 1 хэргийг, гэмт хэргийн бүрэлдэхүүнгүй үндэслэлээр 40 хэргийг хэрэгсэхгүй болгосон байна.

Эрүүгийн хэрэгт холбогдон 410 хүн шалгагдсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 31.4 хувиар буурсан, хэргийн холбогдогчдыг албан тушаалын байдлаар нь авч үзвэл төрийн улс төрийн 42 буюу 10.2 хувь, төрийн захиргааны 79 буюу 19.3 хувь, төрийн тусгай 44 буюу 10.7 хувь, төрийн үйлчилгээний 58 буюу 14.2 хувь, төрийн бус байгууллагын албан тушаалтан 11 буюу 2.7 хувь, бусад 176 буюу 42.9 хувийг эзэлж байна.

Хэргийн холбогдогчоос 28 сэжигтэн, яллагдагчид цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авсан нь өмнөх оны мөн үеээс 17.6 хувиар буурсан байна.

Яллах дүгнэлт үйлдүүлэхээр шилжүүлсэн хэргээс 2015 онд ЭМЯ-ны Төрийн нарийн бичгийн даргаар ажиллаж байсан Н.Түмэндэмбэрэл, ОБЕГ-ын Гал түймэртэй тэмцэх газарт тасгийн даргаар ажиллаж байсан Д.Тогооням, ИХШХЕГ-ын хяналт шалгалтын улсын ахлах байцаагч Ж.Пунцаг, Увс аймгийн Өмнөговь сумын сургуулийн захирал Б.Лхамсүрэн, Налайх дүүргийн Цагдаагийн хэлтсийн мөрдөн байцаагч М.Гансүлд, Ерөнхий сайдын ахлах зөвлөх асан Л.Гансүх, Цэвэр агаар сангийн захирал Н.Хүрэлсүх, ня-бо М.Хулан нарын 68 хүнд холбогдох эрүүгийн **24** хэрэг шүүхээр шийдвэрлэгдсэн.

Гэмт хэргийн улмаас 46 тэрбум 478.3 сая төгрөгийн хохирол учирснаас мөрдөн байцаалтын шатанд 2 тэрбум 921.3 сая төгрөгийн хохирлыг нөхөн төлүүлсэн, 11 тэрбум 276.9 сая төгрөгийн эд зүйлийг битүүмжлэн хамгаалсан, 800.5 сая төгрөгийн нуугдмал мөнгө, эд хөрөнгө илрүүлсэн байна.

Шүүхээс 8.847.242.855 төгрөгийг улсын орлого болгох шийдвэр гарсан дүнтэй ажилласан байна.

ДҮГНЭЛТ

Авлигатай тэмцэх газрын хэлтэс, албадын 2015 онд хийж гүйцэтгэсэн ажлын тайланг нэгтгэхэд Авлигын эсрэг хуулиар хүлээсэн үндсэн чиг үүргээ Авлигатай тэмцэх газар зохих ёсоор гүйцэтгэсэн байна гэж дүгнэх боломжтой байна.

Авлигатай тэмцэх газар, Азийн хөгжлийн банк, Олон улсын эдийн засгийн хөгжил, хамтын ажиллагааны байгууллага, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр хамтран Ази, Номхон далайн орнуудын Авлигын эсрэг санаачилгын 20 дахь удаагийн Удирдах зөвлөлийн уулзалт, 13 дахь удаагийн бүс нутгийн семинарыг гадаадын 31 орны 80 гаруй төлөөлөгчийг оролцуулан Улаанбаатар хотноо 2015 оны 11 дүгээр сарын 18-20-ны өдрүүдэд амжилттай зохион байгууллаа.

Архив, албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэгт бэлтгэх ажлыг сайтар зохион байгуулж, байгууллага нийт дүнгээр “А” үнэлгээ авсан байна.

Төсөв, өмч хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах зорилгоор төсвийн удирдлагыг хэрэгжүүлэх шийдвэр, үйл ажиллагааны ил тод, нээлттэй, ойлгомжтой байх, түүнд олон нийтийн хяналтыг бий болгох боломжоор хангах, төсвийн гүйцэтгэл, төсвийн төсөлтэй холбоотой санал, дүгнэлт, судалгаа болон хэлтэс, албадаас байгуулж буй ажлын гэрээ, тэдгээрийн хэрэгжилтэд хяналт тавих, түүнчлэн шилэн дансанд байршуулах мэдээллийг цаг тухайд нь оруулах багц ажлыг гүйцэтгэв.

2015 онд батлагдсан урсгал зардлын төсвийн санхүүжилт болон хөрөнгө оруулалтын зардлын төсвийг сар бүрийн хуваарийн дагуу зарцууллаа. Байгууллагын 2016 оны урсгал, хөрөнгө оруулалтын зардлыг хэлтэс, албадаас саналыг авч нэгтгэн Сангийн яаманд хугацаанд нь хүргүүлж, УИХ-аар төсөв батлуулах, төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээг хуульд заасан хугацаанд төрийн санд хүргүүлэх, төрийн болон орон нутгийн хөрөнгөөр худалдан авах бараа, ажил, үйлчилгээний төлөвлөгөө боловсруулж, холбогдох яамдад хүргүүлэх, үндсэн хөрөнгө, бараа материал, цалин хөлс, НДШ, ХХОАТ-тай холбоотой тооцоог хийх, баланс гаргах зэрэг багц ажлыг хангалттай сайн гүйцэтгэсэн.